

“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023- 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

Орхон аймаг

2025.12.10

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	2023 онд хэрэгжүүлсэн ажил	2024 онд хэрэгжүүлсэн ажил	2025 онд хэрэгжүүлсэн ажил	Хэрэгжилтийн хувь
Зорилт1: Гепатитын вирусийн халдвараас сэргийлэх эрүүл мэндээ хамгаалах зөв дадал хэвшилд иргэдийг сургах, дархлаажуулалтыг өргөжүүлэх, халдвараас сэргийлэх, хянах цогц арга хэмжээг хэрэгжүүлэн хүн амын халдвар авах эрсдэлийг бууруулна.						
1.1.Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх.	1	Гепатитын В вирусийн вакцин, иммуноглобулин, тавт вакцины хамралтыг үнэлэх.	Гепатитын В вирусийн вакцинд 24 цагийн дотор хамрагдвар зохих 2230 хүүхдээс 2226 хүүхэд хамрагдаж, хамралт 99,8%, тавт вакцины 1-р тунгийн хамралт 99,7%, 2-р тунгийн хамралт 99,7%, 3-р тунгийн хамралт 99,8% байна.	Гепатитын В вирусийн вакцинд 24 цагийн дотор хамрагдвар зохих 2017 хүүхдээс 2005 хүүхэд хамрагдаж, хамралт 99,2%, тавт вакцины 1-р тунгийн хамралт 100%, 2-р тунгийн хамралт 99,9%, 3-р тунгийн хамралт 99,8% байна.	В гепатитын 24 цагийн доторх хамралт 99,2%, Тавт вакцины бүрэн тунгийн хамралт 99,9% байна.	100%
	2	Гепатитын В вирусийн вакцины сайн дурын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх.	Гепатитын В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1267 хүн тун вакцин хийлгэсэн бөгөөд 1-р тунд 517, 2-р тунд 424, 3-р тунд 329 хүн хамрагдсан байна. Өнгөрсөн оноос 56 хүн тун нэмэгдсэн байна.	Гепатитын В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1356 хүн тун вакцин хийлгэсэн бөгөөд 1-р тунд 532, 2-р тунд 425, 3-р тунд 399 хүн хамрагдсан байна. Өнгөрсөн оноос 89 хүн тун нэмэгдсэн байна.	Гепатитын В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад давхардсан тоогоор 1770 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 414 хүн тун нэмэгдсэн байна.	100%
1.2.Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, аюулгүй	3	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ын халдварын сэргийлэлт, хяналтын үнэлгээг тогтмолжуулах.	Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг батлуулан 83%-тай хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл мэндийн сайдын А/537	Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж, хэрэгжилт 95%-тай байна. “Эрүүл мэндийн ажилтны гарын	-Орхон аймгийн Засаг даргын А/472 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй “Аймгийн халдварын сэргийлэх хяналтын салбар зөвлөл”-ийг шинэчлэн батлуулж 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай байна.	95%

тарилга, цусны аюулгүй байдлыг сайжруулах, гепатитын вирусийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах.			дугаар тушаалд заасны дагуу эрүүл мэндийн байгууллагуудын цагаан хэрэгслээр хангасан тухай мэдээлэл, угаалгын газрын үйл ажиллагаанд хийгдсэн үнэлгээний дүнг нэгтгэн хүргүүлсэн.	ариун цэвэр сахиx өдөр”,-ийг тэмдэглэн өнгөрүүлж эрүүл мэндийн байгууллагын ажилчдын гар угаалтын дундаж түвшин 60,5% үнэлэгдсэн. “Халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг дээшлүүлэх 7 хоног” аяныг өрнүүлж Эрүүл мэндийн сайдын А/537, А/538, А/539 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан.	-Шүдний мэргэжилтнүүдийн холбоо болон ортой 3 клиник тархвар судлаачийг гэрээтээр ажиллуулж улирал тутам дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж байна. - “Эрүүл мэндийн ажилтны гарын ариун цэвэр сахиx өдөр”,-ийг тэмдэглэн өнгөрүүлж эрүүл мэндийн байгууллагын ажилчдын гар угаалтын дундаж түвшин 61,7% үнэлэгдсэн.	
	4	Эрүүл мэндийн ажилтнуудыг халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр чадавхжуулах.	Эрүүл мэндийн байгууллагуудын ХСХ-ын чиглэлээр чадавхижуулах ЭМГ-аас явуулсан сургалтанд 231 эмч, Монголын тархвар судлаач эмч нарын нийгэмлэгтэй хамтран Халдвар хяналтын ажилтан бэлтгэх сургалтад 47 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан нь нийт эмч эмнэлгийн мэргэжилтний 30,9%-ийг эзэлж байна.	Халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулахтай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх чиглэлээр 278, Монголын тархвар судлаач эмч нарын нийгэмлэгтэй хамтарсан ХСХ ажилтанг чадавхижуулах сургалтанд 57 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан нь нийт эмч эмнэлгийн мэргэжилтний 37%-ийг эзэлж байна байна.	Эрүүл мэндийн ажилтнуудыг ХСХ-ын чиглэлээр 4 удаагийн цахим, 6 удаагийн танхимын сургалтанд давхардсан тоогоор 473 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан нь нийт эмч эмнэлгийн мэргэжилтний 63%-ийг эзэлж байна байна. Өмнөх оноос 26%-аар өссөн үзүүлэлттэй байна. - Гоо сайхны үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтыг Орхон аймаг дахь “Үсчин гоо сайханчдын холбоо”, Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэг (МТХСЭНН)-тэй хамтран зохион байгуулж 27 хүн хамрагдсан.	90%
	5	Эрүүл мэндийн байгууллагын	Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл,	Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл,	Эрүүл мэндийн байгууллагуудын төрөл, үзүүлж буй тусламж	100

		халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх.	үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу 16 байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийж зөвлөмжөөр хангалаа.	үзүүлж буй тусламж үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 27 байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийж зөвлөмжөөр хангалаа.	үйлчилгээ чиглэлээс хамааран хуваарийн дагуу дэмжлэгт хяналтыг 56 эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах чиглэлээр дэмжлэгт хяналт 2, аян 2, хэлэлцүүлэг 3, тэмдэглэлт өдөр 3 зохион байгуулан, мэргэжил аргазүй, зөвлөмжөөр хангаж ажилласан.	
	6	Эрүүл мэндийн ажилтнуудын Гепатитын вирусийн халдвар илрүүлэг, сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйлд өртөлтийн мэдээ, мэдээллийг одоогийн цахимд нэгтгэх	Эрүүл мэндийн ажилтнуудын Гепатитын вирусийн халдвар илрүүлэг, сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйлд өртөлт бүртгэгдээгүй, цахимд нэгтгэн сар бүр оруулж байна.	БОЭТ-ийн Лабораторийн нэгдсэн тасагт В вирусийн эсрэг вакцины дархлаа тогтцын шинжилгээг шинээр нэвтрүүлэн уг шинжилгээнд Эрүүл мэндийн салбарын 200 эмч, ажилтан хамрагдсанаас 71 эмч эмнэлгийн мэргэжилтний дархлал тогтоц 100мл/IU-ээс доош гарсан байна. Эрүүл мэндийн ажилтнуудын Гепатитын вирусийн халдвар илрүүлэг, сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйлд өртөлт бүртгэгдээгүй, цахимд нэгтгэн сар бүр оруулж байна.	Тайлант хугацаанд ЭМБ-уудын эрүүл мэндийн ажилтан эрсдэлт хүчин зүйлд өртсөн 5 тохиолдол бүртгэгдсэн. Өртсөн тохиолдлыг бүртгэн, хариу арга хэмжээ авч цахим мэдээллийн сан үүсгэсэн.	100
1.3.Эхээс хүүхдэд гепатитын В, С вирусийн халдвар дамжихаас	7	Жирэмсэн эмэгтэйчүүдэд хийх вируст гепатитын халдварын илрүүлэг,	Тайлант хугацаанд 1562 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, үүнээс жирэмсний эхний 3 сартайд 1538 буюу 98,5 хувь нь хяналтад орж,	Тайлант хугацаанд 1692 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, үүнээс эхний 3 сартайд 1679 буюу 99,2 хувь нь хяналтад орж, өмнөх оны	Тайлант хугацаанд шинээр хяналтанд 1453 жирэмсэн эхийг авч гепатит В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд 100% хамруулсан. Түргэвчилсэн шинжилгээгээр anti-HCV эерэг 16	100

урьдчилан сэргийлэх, тандалт, хяналтыг сайжруулах		тандалт, хяналтыг сайжруулах.	өмнөх оны мөн үеэс эрт үеийн хяналт 2,1 хувиар нэмэгдсэн байна. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд 100% хамруулсан. Хурдавчилсан шинжилгээгээр 19 эмэгтэй anti-HCV эерэг илэрснээс С вирус тоологдсон / идэвхтэй хүн бүртгэгдээгүй, 22 эмэгтэй HBsAg эерэг илэрснээс В вирус тоологдсон / идэвхтэй 4 хүн бүртгэгдэж 100% эмчилгээнд хамрагдсан байна.	мөн үеэс эрт үеийн хяналт 0,7 хувиар нэмэгдсэн. Шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн гепатит В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд 100% хамруулсан. Хурдавчилсан шинжилгээгээр 19 эмэгтэй anti-HCV эерэг илэрснээс С вирус тоологдсон / идэвхтэй хүн бүртгэгдээгүй, 22 эмэгтэй HBsAg эерэг илэрснээс В вирус тоологдсон / идэвхтэй 4 хүн бүртгэгдэж 100% эмчилгээнд хамрагдсан байна.	эмэгтэй, HBsAg эерэг илэрснээс 27 эмэгтэй бүртгэгдэж нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд хянагдаж байна.	
	8	Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд хийсэн дархлаажуулалт [төрсний дараах 12 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцины эхний тунг, В вирусийн эсрэг өвөрмөц иммуноглобулинта й хамт хийнэ],	Тайлант хугацаанд 2227 эх төрснөөс 33/1.5%/ В вирус тээгч эх төрсөн байна. “Элэг гэмтээгч В вирусын халдваргүй нярай” төслийн хүрээнд төрсөн нярайг В вирусын халдвараас сэргийлэх зорилгоор 24 цагийн дотор В гепатитын вакцин 21 нярайд, “Нераbig” 12/36.4%/ нярайд гепатитын В вирусийн эсрэг вакцины эхний тунг, В вирусийн	Тайлант хугацаанд 2017 эх төрснөөс 39/1.9%/ В вирус тээгч эх төрсөн байна. “Элэг гэмтээгч В вирусын халдваргүй нярай” төслийн хүрээнд төрсөн нярайг В вирусын халдвараас сэргийлэх зорилгоор 24 цагийн дотор В гепатитын вакцин 27 нярайд, “Нераbig” 6/15.4%/ нярайд гепатитын В вирусийн эсрэг вакцины эхний тунг, В вирусийн эсрэг өвөрмөц	Тайлант хугацаанд 1761 эх төрснөөс 27/1,5%/ В вирус тээгч эх төрсөн байна. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн 3 нярайд 12 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцины эхний тунг, В вирусийн эсрэг өвөрмөц иммуноглобулин (HBlg) хийж цаашид өвчлөхөөс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.	100

		лабораторийн шинжилгээ [6 сартайд HBsAg, HBsAb, HbcAb илрүүлнэ]-ний хамралтыг үнэлэх.	эсрэг өвөрмөц иммуноглобулинтай хамт хийж цаашид өвчлөхөөс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.	иммуноглобулинтай хамт хийж цаашид өвчлөхөөс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.		
	9	Гепатитын C вирусийн халдвартай эхээс төрсөн хүүхдэд 3 настайд аHCV илрүүлэг шинжилгээг хийж эхээс хүүхдэд халдвар дамжсан эсэхэд тандалт хийх.	-	-	Гепатитын C вирусийн халдвартай эхээс төрсөн 3 нярай 3 нас хүрээгүй тул аHCV илрүүлэг шинжилгээ хийгдээгүй байна.	-
	10	Жирэмсний хяналт болон төрсний дараах эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх.	Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээнд улирал тутам үнэлгээ хийх, магадлан хэлэлцэх хурлыг хийж зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Зөвлөмжийн биелэлт 91,5% байна. Төрсний дараа 42 хоногийн дотор 1817 эхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад авсан. Үүнээс B вирусийн халдвар тээгч төрсөн 12 эхийг хяналтад бүрэн хамрагдсан байна.	Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээнд улирал тутам үнэлгээ хийх, магадлан хэлэлцэх хурлыг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 93,4% байна. Төрсний дараа 42 хоногийн дотор 1683 эхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад авсан. Үүнээс B вирусийн халдвар тээгч төрсөн 6 эхийг хяналтад бүрэн хамрагдсан байна.	Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээнд улирал тутам үнэлгээ хийх, магадлан хэлэлцэх хурлыг хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 95% байна. Төрсний дараа 42 хоногийн дотор 1659 эхийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад авсан. Үүнээс B вирусийн халдвар тээгч төрсөн 3 эхийг хяналтанд авч, эмэн эмчилгээ хийсэн.	100

Зорилт 2: Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулж, хүн амд чанартай багц тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

2.1.Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглалыг гарган, удирдамж шинэчлэн, эрсдэлт бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	11	Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын тусламж үйлчилгээний зураглал /каскад/ улс, аймаг, дүүргийн хэмжээнд гаргах.	Аймгийн хэмжээнд Жаргалант сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн элэг цөсний кабинет, Эрдэнэт сувиллын цогцолбор, Эрдэнэт медицина төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдэд Гепатитын В, С, Дельта вирусийн илрүүлэг шинжилгээ хийгдэж, элэгний эмгэгийг оношлох, эмчлэх, хянах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	Аймгийн хэмжээнд Жаргалант сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын цогцолбор, Баянөндөр мед Нэгдсэн эмнэлэг, Талын булаг эмнэлэг, Эрдэнэт медицина төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгүүдэд Гепатитын В, С, Дельта вирусийн илрүүлэг шинжилгээ хийгдэж, элэгний эмгэгийг оношлох, эмчлэх, хянах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/18 тоот тушаалын дагуу сар бүр Эрүүл мэндийн газарт мэдээ ирүүлэн ажилладаг.	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/18 тоот тушаалын дагуу орон нутагт тохирсон зураглал гаргаж, Жаргалант сум, 8 өрхийн эрүүл мэндийн төвөөс сар бүрийн мэдээ LINELIST-ээр эрүүл мэндийн газарт авч, мэдээг нэгтгэн ХӨСҮТ-д илгээж ажиллаж байна.	100
	12	Гепатитын вирусийн цочмог халдвар, Гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдварын тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын удирдамжийг	-	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/18 тоот тушаалын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэн ажилладаг. Сайдын тушаал танилцуулах сургалтыг зохион байгуулж нийт 25 эмнэлгийн ажилтан хамруулсан.	Гепатитын тусламж үйлчилгээтэй холбоотой бодлого, хууль эрхзүйн баримт бичгийг танилцуулах сургалт 1 удаа зохион байгуулж холбогдох 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	70

		шинэчлэн боловсруулж, мөрдөнө.				
2.2.Лаборатори йн чадавхийг сайжруулах замаар гепатитын вирусийн халдвар, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын оношилгооны баталгааг хангах, орон нутагт вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг тогтмолжуулах.	13	Гепатитын вирусийн халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурын үнэлгээ хийх.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвд гепатит В вирусийн нийт 4089 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1488 тохиолдлоор нэмэгдэж, нийт шинжилгээний 196 буюу 4,8 хувь нь төлбөртэй хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 93 тохиолдлоор буурч, 3893 буюу 95.2 хувь нь төлбөргүй хийж, өнгөрсөн мөн оны үеэс 1581 тохиолдлоор нэмэгдсэн байна. Гепатит С вирусын нийт 4073 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1689 тохиолдлоор нэмэгдэж, нийт шинжилгээний 191 буюу 4,7 хувь нь төлбөртэй хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 88 тохиолдлоор буурч, 3882 буюу 95.2 хувь нь төлбөргүй хийж, өнгөрсөн мөн оны үеэс 1777 тохиолдлоор нэмэгдсэн байна.	Сум өрхийн эрүүл мэндийн төвд нийт гепатит В вирусийн 5101 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1012 тохиолдлоор нэмэгдэж, нийт шинжилгээний 173 буюу 3,3 хувь нь төлбөртэй хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 23 тохиолдлоор буурч, 4928 буюу 96,6 хувь нь төлбөргүй хийж, өнгөрсөн оны мөн үеэс 1035 тохиолдлоор нэмэгдсэн байна. Гепатит С вирусын нийт 5054 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 981 тохиолдлоор нэмэгдэж, нийт шинжилгээний 174 буюу 3,4 хувь нь төлбөртэй хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 17 тохиолдлоор буурч, 4880 буюу 96,5 хувь нь төлбөргүй хийж, өнгөрсөн мөн оны үеэс 998 тохиолдлоор нэмэгдсэн байна. Мөн Элэг бүтэн 2022-2025 хөтөлбөрийн хүрээнд	Сум өрхийн эрүүл мэндийн төвд нийт гепатит В вирусийн 6726 шинжилгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1625 тохиолдлоор нэмэгдсэн, С вирусийн 6693 шинжилгээ хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 1639 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт шинжилгээ 100% үнэ төлбөргүй хийгдсэн байна.	100

			БОЭТ-ийн Лабораторийн нэгдсэн тасагт В вирусийн эсрэг вакцины дархлаа тогтцын шинжилгээг шинээр нэвтрүүлэн уг шинжилгээнд Эрүүл мэндийн салбарын 200 эмч, ажилтан хамрагдсанаас 71 эмч эмнэлгийн мэргэжилтний дархлал тогтоц 100мл/IU-ээс доош гарсан байна. Үүний 22/10мл/IU-ээс бага/нь В вирусийн эсрэг вакцины 3 тун, 49/ 100мл/IU-ээс бага/ нь 1 тун вакцин хамрагдсан.	Засгийн газрын санхүүжилтээр гепатит В, Д вирус тоолох шинжилгээнд нийт 260 хүн хамруулахаар төлөвлөсөнөөс 160 хүнийг В тоолох шинжилгээнд хамруулсан, Д тоолох шинжилгээг 2025 оны 3 дугаар сард 100 хүнд хийхээр төлөвлөөд байна. Дельта вирус илрүүлэх шинжилгээнд нийт 173 хүн хамрагдсан.		
--	--	--	---	---	--	--

Зорилт 3: Цахим бүртгэлийн программыг хөгжүүлэх замаар гепатитын вирусийн цочмог болон архаг халдварын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

3.1.Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын цахим бүртгэлийг хэрэглэгчдэд ээлтэй болгон хөгжүүлэх, ашиглалтыг сайжруулах.	14	Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, эмчилгээ, хяналтын удирдамжийн дагуу одоогийн цахим бүртгэлийн программыг хөгжүүлж тандалтыг сайжруулах.	СӨЭМТ-ийн дүн бүртгэгч, статистик хариуцсан мэргэжилтэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр В, С, Дельта вирусийн архаг халдвартай оношлогдсон өвчтөний эмчилгээ, эмчилгээний хяналтын лабораторийн шинжилгээний дүн бүхий мэдээллийн санг бүрдүүлж ажилладаг. Тайлант хугацаанд 3	СӨЭМТ-ийн дүн бүртгэгч, статистик хариуцсан мэргэжилтэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр В, С, Дельта вирусийн архаг халдвартай оношлогдсон өвчтөний эмчилгээ, эмчилгээний хяналтын лабораторийн шинжилгээний дүн бүхий мэдээллийн санг бүрдүүлж ажилладаг. Тайлант хугацаанд 4 тохиолдол бүртгэгдсэн	СӨЭМТ-ийн дүн бүртгэгч, статистик хариуцсан мэргэжилтэн Ehealth программд бүртгэж урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээгээр В, С, Дельта вирусийн архаг халдвартай оношлогдсон өвчтөний эмчилгээ, эмчилгээний хяналтын лабораторийн шинжилгээний дүн бүхий мэдээллийн санг бүрдүүлж ажилладаг.	100
--	----	---	--	--	--	-----

			тохиолдол бүртгэгдсэн байна.	байна.		
	15	Цахим программыг ашиглах, мэдээллийн цахим сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах талаар, мэргэжил, арга зүйгээр хангах, программын ашиглалтад эрүүл мэндийн байгууллагын удирдлагаас хяналт тавих.	Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн сургалтыг 3 сарын 01-ний өдөр, шүдний эмнэлгүүдийн сургалтыг 03 сарын 02-ны өдөр, клиникүүдийн сургалтыг 03 сарын 17-ны өдөр тус тус зохион байгуулсан. Сургалтад хамрагдвал зохих 67 байгууллагаас 48 байгууллагын бүртгэл мэдээ хариуцсан эмч, мэргэжилтнүүд оролцсон. - Эрүүл мэндийн байгууллагуудын статистик, бүртгэл мэдээ хариуцсан эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг сайжруулах цахим 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 39 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.	Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан мэдээлэл технологийн мэргэжилтэн болон статистикч эмчийн сургалтад БОЭТ, ЭМГ-ын 4 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдсан.	Ehealth программд бүртгэж ажиллах сургалтыг 1 удаа хийж, 12 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.	100
3.2.Гепатитын В, С вирусийн архаг халдвартай өвчтөний оношилгоо, вирусийн эсрэг	16	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон	Элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 3620 иргэн хамрагдсанаас 120 хүн буюу 3.3%, С вирус илрүүлэх шинжилгээнд 3610 иргэн	Элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 1565 иргэн хамрагдсанаас 28 хүн буюу 1.8%, С вирус илрүүлэх шинжилгээнд 1559 иргэн хамрагдсанаас 24 буюу 1.5% нь эерэг	Элэгний В вирус илрүүлэх шинжилгээнд 6726 иргэн хамрагдсанаас 45 хүн буюу 0,67%, С вирус илрүүлэх шинжилгээнд 6693 иргэн хамрагдсанаас 80 буюу 1.2% нь эерэг илэрсэн байна. Вируст	100

шууд үйлчилгээтэй эмийн эмчилгээний хяналтын мэдээллийг элэгний хатуурал, хорт хавдрын эргэх дуудах тогтолцоонд ашиглах боломжийг бүрдүүлэн, цогц мэдээллийн санг бий болгох		халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны мэдээллийн санд суурилан В, С, дельта вирусийн архаг халдвартай өвчтөний эмчилгээний хяналтын мэдээллийн санг бүрдүүлэх.	хамрагдсанаас 121 буюу 3.4% нь эерэг илэрч 65 хүн эмчилгээнд хамрагдсан. Элэгний В, С вирусээс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтыг таниулах 7 төрлийн зурагт хуудсыг цахимаар 8081 хүнд түгээж, 88 хүнийг сургалтад хамруулсан байна. Вируст гепатитын 6 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.6 промилл байна.	илэрсэн байна. Вируст гепатитын 3 тохиолдол шинээр бүртгэгдэж 10000 хүн амд 0.28 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оноос 0,32 тохиолдлоор буурсан байна.	гепатитын 3 тохиолдол шинээр бүртгэгдэж 10000 хүн амд 0.3 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны түвшинд байна.	
	17	Гепатитын В, С, Дельта вирусийн архаг халдвар, түүний шалтгаант элэгний хатуурал, хорт хавдар, нас баралтыг бүртгэж тооцоолон, эмнэлэгт суурилсан харуулдан тандалтын тогтолцоог бий болгох.	Элэгний хорт хавдрын нас баралт 45 тохиолдол 10000 хүн амд 4.2 промилл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 промилл буурсан, элэгний хатуурлын нас баралт 11 тохиолдол 10000 хүн амд 1.0 промилл өмнөх оны мөн үеэс 0.1 промилл буурсан.	Элэгний хорт хавдрын нас баралт 23 тохиолдол 10000 хүн амд 2.2 промилл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,4 промилл өссөн, элэгний хатуурлын нас баралт 7 тохиолдол 10000 хүн амд 0.7 промилл өмнөх оны мөн үеэс 0.3 промилл буурсан.	Элэгний хорт хавдрын нас баралт 13 тохиолдол 10000 хүн амд 1.2 промилл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 промилл буурсан.	100
Зорилт 4: Гепатитын В, С, Дельта вирусийн халдвар, элэгний хатуурал, хорт хавдрын тандалт, оношилгоо, эмчилгээний чиглэлээр хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үр дүнг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.						
4.1.Гепатитын В, С, Дельта вирусийн	18	Олон улсын байгууллагатай хамтран вируст	Үнэлгээ хийгдээгүй байна.	Үнэлгээ хийгдээгүй байна.	Үнэлгээ хийгдээгүй байна.	0

халдварын үнэлгээг хийн судалгааны ажлыг эрчимжүүлнэ .		гепатитын тархалтыг таслан зогсоосныг баталгаажуулах урьдчилсан үнэлгээ хийх				
	19	Эрүүл мэндийн салбарын эрдэмтэдтэй хамтран гепатитын вирусийн халдвар, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.	Судалгааны ажил хийгдээгүй байна.	Эрдэнэт Медикал эмнэлэг дээр эрт илрүүлгийн шинжилгээнд ГВВ, ГСВ, ХДХВ, тэмбүүгийн халдварын илэрсэн байдал сэдэвт судалгааны ажлыг аймгийн эрүүл мэндийн салбарын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн. Судалгааны тайлан 1.2022-2024 оны байдлаар эрт илрүүлэгт орсон үйлчлүүлэгчдийн ГВВ, ГСВ, ХДХВ, Тэмбүүгийн халдварыг харьцуулж үзэхэд ГВВ халдварын байдал 2022-6,2%, 2023- 7,4%, 2024-5,4%-тай байна. ГСВ халдварын байдал 2022-6,1%, 2023- 5,9%, 2024-8,2%-тай байна. ХДХВ-н халдвар 2022-2024 онд илрээгүй байна. Тэмбүүгийн халдварыг харьцуулж үзэхэд 2022-7,1%, 2023- 10%, 2024-5,3%-тай байсан байна. 2.ГВВ-н халдвар эерэг	Судалгааны ажил хийгдээгүй байна	70

				гарсан үйлчлүүлэгчид насны хувьд авч үзэхэд 31-45 насны бүлэгт өндөр байгаа бөгөөд энэ нийт эерэг гарсан тохиолдлын 55.3%, тухайн насны бүлгийн үйлчлүүлэгчийн 9,2%-ийг эзэлж байна. ГВВ-н халдвар нийт оролцогчдын 6,2 хувьд эерэг илэрсэн. Хүйсийн хувьд харьцуулахад эрэгтэй хүйст давамгай буюу 8,6% нь халдвартай байна. ГСВ-ийн халдварын хувьд эмэгтэйчүүдийн 6.3%, эрэгтэйчүүдийн 4,8 хувьд илэрсэн. Насны бүлгийн хувьд 46-60 насныханд 38.8% -д халдварын эерэг тохиолдол оношлогдсон. Харин хавсарсан халдварын 6 тохиолдол илэрсэн ба эрэгтэй хүйст давамгай байна. Насны бүлгийн хувьд 46-60 насны бүлэгт 66% нь оношлогдсон.		
Үнэлгээний хувь 85,5%						

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЭМНЭЛГИЙН ДОТООД ХАЛДВАР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч.МӨНХЗУЛ

ХЯНАСАН: ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2020 он	Хүрсэн түвшин		
			2023 он	2024 он	2025 он
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт:					
1	Тав хүртэлх насны хүүхдийн дундах гепатитын В вирусийн [HBsAg+] тархалт	0,53 хувь* (2011)	-	-	-
2	100.000 хүн ам дахь гепатитын В вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол	1,1	0.6	0.28	0.2
3	100,000 хүн ам дахь гепатитын С вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол	3,4	-	-	0.6
4	Гепатитын В, С вирусийн халдвараас үүдэлтэй элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (100,000 хүн амд)	5,5 (2015)	4.2	2.2	1.2
5	HBsAg эерэг эхээс төрсөн HBsAg эерэг хүүхдийн илрүүлгийн хувь	0	1.5%	1.9%	0
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:					
6	Нярайг төрсний дараах 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулсан хувь	98.5%	100%	99,2%	99.4%
7	Тавт вакцины бүрэн тунгийн хамралтын хувь [товлолын дагуу, гурван тунд хамрагдсан байх]	96.4%	99,8%	99,8%	99.8%
8	Гепатитын В вирусийн архаг халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор В вирусийн эсрэг вакцин, иммуноглобулин (HBIG)-ыг хавсарч хэрэглэсэн хувь	-	36.4%	15.4%	-
9	Гепатитын В, С, Дельта вирусийн шалтгаант элэгний хорт хавдар, элэгний хатуурлын хувь	Тодорхойгүй	-	-	-
10	Тухайн жилд гепатитын В вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	41%	-	-	42%
11	Тухайн жилд гепатитын С вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	60%	-	-	72%
12	Тухайн жилд гепатитын Дельта вирусийн халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь	10%	-	-	45%
13	Гепатитын В вирусийн архаг халдвартай амьдарч байгаа		-	-	15%

	иргэдээс оношлогдсон хүний эзлэх хувь	53%			
14	Гепатитын С вирусийн архаг халдвартай амьдарч байгаа иргэдээс оношлогдсон хүний эзлэх хувь	25%	-	-	12%
15	Төрийн болон олон улсын байгууллагын санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны тоо	1	-	-	-